



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 1/298

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх Г олгох тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчдыг бэлчээрийн менежментийн чиглэлээр чадавхижуулах сургалт хийх ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хөгнө-Мээж” Төрийн бус байгууллагатай 25 726 500 /хорин таван сая долоон зуун хорин зургаан мянга таван зуу/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг олгосугай.

2. Сургалт зохион байгуулах үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, чанарын өндөр түвшинд хүлээн авахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү ажлын санхүүжилтийг холбогдох хууль, журмын дагуу 2018 оны Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгыг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ